



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 09 сарын 02 өдөр

Дугаар А/161

Батширээт сум

**Зам тавих барилга угсралтын ажил
гүйцэтгэх газрын зөвшөөрөл
олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3, Авто замын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумаас Биндэр сум чиглэлийн авто зам барихтай холбоотойгоор Батширээт сумын 3-р багийн дэвсгэрт дамжин өнгөрөх авто замыг барьж ашиглалтад оруулахад тус суманд 46.3 км урттай газар ашиглах бөгөөд “Түм Арвижих” ХХК-д зам тавигдаж дуусах хүртэлх хугацаанд тус газрыг ашиглах зөвшөөрөл олгосугай.

2. Зам тавих газрыг зориулалтын дагуу зохистой ашиглахыг “Түм Арвижих” ХХК-д даалгасугай.

3. Авто замын газрын ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын Улсын байцаагч /Б.Мөнх-Очир/, Газрын даамал /Д.Батчимэг/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АЛТАНГЭРЭЛ

23250/218